



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Улаанбаатарын Их Сургууль УТҮГ-ын 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж 76.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг зөрчин төлөвлөгөөнд тусгагдаагүй 47.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг нийт 124.0 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатарын Их Сургууль УТҮГ-ын 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Улаанбаатарын Их Сургууль УТҮГ-ын Удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

2.1. Улаанбаатарын Их Сургууль УТҮГ-ын 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, шалгалтын мөрөөр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулах;

2.2. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

3. Улаанбаатарын Их Сургууль УТҮГ -ын гүйцэтгэх захирал С.Байгалсайханд дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллах;

3.2. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэж байгаа ажиллагааг таслан зогсоох;

0000237

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2019 оны 03 дугаар сарын 07 ний өдрийн
84 дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчинэрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр худалдан авалт хийсэн	Захирал С.Байгалсайхан Ерөнхий ня-бо О.Туяа	76,573.0	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах
2	Төлөвлөгөөнд тусгуулж батлуулаагүй худалдан авалт	Захирал С.Байгалсайхан Ерөнхий ня-бо О.Туяа	47,431.00	Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмыг мөрдөж ажиллах
Дүн			124,007.0	